



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 546

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн 0288 дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 6,021,000.00 (зургаан сая хорин нэгэн мянган) төгрөгийн балансын үнэ, 917,789.00 (есөн зуун арван долоон мянга долоон зуун наян есөн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Ц.Сэргэлэн, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг тус тус даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002483

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн
59.6 дугаар тогтоолын хавсралт

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА ХИЛИЙН 0288 ДУГААР АНГИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ "УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" КОМПАНИД
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм- жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагд- сан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Цахилгааны дэд өртөө	1970	ком	1	4,380,000.00	4,380,000.00	770,710.00	3,609,290.00
2	Трансформатор ТМ 400/10	1970	ком	1	941,000.00	941,000.00	147,079.00	793,921.00
3	Цахилгааны тоолуур	2008	ш	1	200,000.00	200,000.00		
4	Цахилгаан электрон тоолуур	2013	ш	1	500,000.00	500,000.00		
	Нийт дүн					6,021,000.00	917,789.00	4,403,211.00
						(зургаан сая хорин нэгэн мянган)	(есөн зуун арван долоон мянга долоон зуун наян есөн)	(дөрвөн сая дөрвөн зуун гурван мянга хоёр зуун арван нэгэн)